



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/С81

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 255 дугаар
цэцэрлэгийн хөрөнгийг данснаас
дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан 2,962,481.40 /хоёр сая есөн зуун жаран хоёр мянга дөрвөн зуун наян нэгэн төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Баянзүрх дүүргийн 255 дугаар цэцэрлэг /Г.Цэцгээ/-т зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 255 дугаар цэцэрлэг /Г.Цэцгээ/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

11505001579

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 12-дугаар
 сарын 6-өдрийн 0/521 тоот тушаалын хавсралт

Данснаас дансанд шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 255-р цэцэрлэг

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Марк дугаар	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Дансны нэр	
						Нэгж үнэ	Нийт үнэ	Шилжүүлэх данс	Бүртгэх данс
Бусад хангамжийн материал									
1	Бэлтгэлийн ширээ	2018/12/31	никель 150*60см	1	ш	234,481.40	234,481.40	Бусад хангамжийн материал	Тавилга, эд хогшлын данс
2	Бэлтгэлийн ширээ	2019/01/09	никель 180*60см	1	ш	528,000.00	528,000.00		
3	Тавиур /даацын/	2018/12/28	никель 150*50см	1	ш	484,000.00	484,000.00		
4	Тавиур /гал тогоонд даацын/	2019/01/11	төмөр 120*40см	2	ш	264,000.00	528,000.00		
5	Тавиур /гал тогоонд даацын/	2019/09/19	никель	1	ш	484,000.00	484,000.00		
6	Тавиур /даацын/	2019/10/31	төмөр 180*60см	2	ш	352,000.00	704,000.00		
Бусад хангамжийн материалын дүн				8			2,962,481.40		
Нийт эд хөрөнгийн дүн							2,962,481.40		